

**“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2024 оны ээлжит хурлын тэмдэглэл**

2024-04-03

Улаанбаатар хот

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал компанийн сургалтын танхимд 11:20 цагт эхлэв.

Н.Батцэцэг: Өнөөдрийн хурлын даргаар компанийн ТУЗ-ийн 2022-02-16-ны өдрийн тогтоол 03/2024 –оор томилогдсон Ё.Энхтөр ажиллана. Мөн тооллогын комиссын даргаар Б.Доржсамбуу, гишүүдээр П.Ариунжаргал, Х.Цэндсүрэн нар тус тус ажиллана. Энхтөр даргыг хурлаа удирдахыг урья.

Ё.Энхтөр: Сайн байцгаана уу? Хувьцаа эзэмшигчдэд хуралдаа хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье. Хурлын дэг танилцуулъя. Хэлэлцэх асуудлууд:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зорилт
2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
3. “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ ба хороодын 2024 оны зардлын төсөв батлах
4. ТУЗ-ийн гишүүдийн сонгууль

Б.Доржсамбуу /Тооллогын комиссын дарга/: Ирцийн мэдээлэл танилцуулъя.

Хурал нийт 387321 хувьцаа /2024-03-14-ний өдрөөр тасалбар болсон жагсаалтаар/ буюу нийт хувьцааны 95,7 %-ийг төлөөлсөн гишүүд ирсэн тул хурлыг хүчинтэй гэж тооцов.

Ё.Энхтөр: Баярлалаа. Дэгийн дагуу 1-р асуудлаа хэлэлцье: **“Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зорилт”**. Бүх асуудлаа хэлэлцсэний дараа санал, асуулт, шүүмжлэлээ явуулъя.

Ц.Зоригт: Та бүхэнд тараагдсан байгаа хурлын материалд байгаа тайланг товчлон ярья.

- Маркетинг-борлуулалтын талаар:

- 5 573 222 мянган төгрөгний борлуулалт хийсэн нь 2022 оныхоо 168,0 сая төгрөөр илүү байв.
- 1147,23 сая төгрөгийн ашигтай ажилласан.
- 6 нэр төрлийн хивс борлуулснаас Алтанбулаг 69,2 % байна.
- 4800 гаруй сүлжмэл бүтээгдэхүүн борлуулсан.
- Сошиал маркетингийг сурталчилгаандаа нилээд ашигласан.. Хэрэглэгчдийн хандалт ихэссэн.
- Гол өрсөлдөгч өөрчлөгдөж, БНТУ-аас их хэмжээний хивс орж ирэх болсон.
- 1341,0 м2 хивс экспортолсон.

- 8 удаагийн идэвхжүүлэлт, урамшуулал, хямдрал зарласан.

Үйлдвэрлэлийн хүрээнд:

- 50368,8 м2 хивс үйлдвэрлэсэн.

- 266,5 тн ноос бэлтгэсэн.

- Нарийн ээрэхэд 113624 кг ноос оруулж, 80551 кг утас ээрсэн.

- Хялгас ялгнах цехэд 5977 кг ноос оруулж 29,8%-ийн гарцтай байв.

- Аппарат ээрэх цехэд 24/2 номерын ээрмэл 918,5 кг, 12/1 номерын ээрмэл 817,8 кг, гаднын захиалгаар 12/1 номерын ээрмэл 2200 кг тус тус ээрэв.

- Будах цехэд 85 удаагийн будалт хийж, 85381 кг утас будав.

- Туслах үйлдвэрлэлээр 486,7 м2 килим, 114 ширхэг машины суудал, 113 ш эсгийн гудас, 533 ширхэг хивсэн углааш тус тус үйлвэрлэв.

Хүний нөөцийн талаар:

- Оны эхэнд 114 ажилтантай байснаас 21 хүн халагдаж, 42 хүн ажилд шинээр орсноор оны эцэст 135 ажилтантай болов.

- Өдөр ажиллахаас 224 өдөр ажиллаж, ажлын цаг ашиглалт 96,1% байв.

- Ажилтнуудын компанид ажилласан дундаж жил 12 ба нийт ажилтнуудын дундаж нас 46.

- Тэтгэврийн насны 52 хүн ажиллаж байна.

- Төрийн одон медалиар 4 ажилтан, салбарын тэргүүний ажилтнаар 10 хүн шагнагджээ.

- Хоолны талоны үнийг тэглэж, унааны мөнгө өдөрт 1000 төгрөгөөр бодож олгодог болов.

- 8 ажилтанд 8,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгов.

- Ажилчдыг урамшуулах төрөл бүрийн хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлж байна.

Техник технологийн шинэчлэлийн талаар

- Хими-будгийн лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг шинэчилсэн.

- Альфа нэхэх машины бердаг сольж, шинэ нэр төрлийн, өндөр нягттай хивс үйлдвэрлэх боломжтой болсон.

- Суурь утас ороох машин шинээр суурилууллаа.

- Нэхэх 2-р машины электроникийн эд ангийг солив.

- Самнах машин дээр номерын редуктор тавьж хэлбэлзлийг багасгасан.

- Ээрэхийн хонгилын сэнсэнд инвертор тавьж 3550 вт эрчим хүч хэмнэв.

- Оймс, бээлий нэхэх машиныг шинээр суурилуулан ашиглаж байна.

2024 оны үндсэн зорилт:

- Үйлдвэрлэл	52000 м2
- Борлуулалт	6 200 000 мян төгрөг
- Хөрөнгө оруулалт	600,0 сая төгрөг
- Цэвэр ашиг	900,0 сая төгрөг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг	94000 төг/м2

Ё.Энхтөр: Баярлалаа.

2-р асуудалдаа орёё. **Компанийн 2023 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт:**

Л.Цэндээхүү: /Аудитын хорооны гишүүн/:Компанийн балансад “Аяатакс аудит” ХХК аудит хийж урьдчилсан дүгнэлтээ ирүүлсэн байна. Та бүхэнд байгаа материал дээр тодорхой учир би зөвхөн дүгнэлтийг уншъя. /Уншиж танилцуулав./

Ё.Энхтөр: 3-р асуудалд орёё. **“Компанийн ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв батлах”**

Н.Батцэцэг: Хөдөлмөр, цалин хөлсний 3 талт хэлэлцээрийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 20% нэмэгдсэнтэй холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг нэмсэн байгаа.

Ингээд:

- Цалин 64,32 сая төг,
- Урамшуулал 19,2 сая төг,
- Бичиг хэрэгслийн зардал 500,0 мян. төг,
- Хэвлэл, холбооны зардал 2,0 сая төгрөг,
- Сургалт, аттестатчиллын зардал 2,0 сая төгрөг, нийт **88,02 сая төгрөг** төсөвлөсөн.

Ё.Энхтөр: Одоо 4-р асуудал буюу **ТУЗ-ийн сонгууль**. Та бүхэн материалтай танилцаж, саналын хуудсаа бөглөнө үү. Тооллогын комисс санал тоолж байх хугацаанд асуулт, саналаа хэлцгээнэ үү.

С.Пүрэвжав: Хөрөнгийн үнэлгээ хийгдсэн үү?

Ц.Зоригт: 2 жилийн өмнө хийгдсэн. Хөрөнгийн үнэлгээ хийлгэхээр татвар, зардал нэмэгддэг юм билээ.

С.Пүрэвжав: “Номин” ХХК-д талбайгаа хэдээр түрээсэлдэг вэ? Хэдэн м2 вэ?

Ц.Зоригт: 4500 м2 талбай, 1 м2-ийг нь 11000 төгрөгөөр түрээсэлдэг.

Ё.Энхтөр: Тооллогын дүн гарсан байна.

Б.Доржсамбуу: Тооллогын комиссын 3 тогтоол уншиж сонсгов.

- Саналын хайрцганд нийт 17 саналын хуудас ирснээс хүчингүй хуудас байхгүй байна.

- Ердийн аргаар нэгтгэсэн саналын хуудасны хэлэлцсэн асуудлуудад өгсөн саналын дүнгээр:

- “Улаанбаатар хивс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа, 2024 оны зорилт гэсэн асуудалд 100% зөвшөөрсөн санал өгсөн байна.

- “Улаанбаатар хивс” ХК-ийн 2023 оны тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт” асуудалд мөн 100 % зөвшөөрсөн санал өгсөн байна.

- “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв” асуудалд мөн 100% зөвшөөрсөн санал өгсөн байна.

- Кумулатив аргаар өгсөн Саналын үр дүн:

- ТУЗ-ийн ердийн гишүүдэд:

1. Ц.Зоригт	15,56 %
2. Л.Цэндээхүү	15,55 %
3. З.Мөнхмаа	15,55 %
4. Ш.Энхбаяр	18,89 %
5. З.Эрдэнээ	15,55 %
6. У.Мөнхзул	18,89 % тус тус санал авч ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон

байна.

- ТУЗ-ийн хараат бус гишүүдэд:

1. Б.Баясгалан	31,11 %
2. Ё.Энхтөр	31,11 %
3. Ц.Энхболд	37,79 % тус тус санал авч ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон


байна.

Ё.Энхтөр: Хурлын төлөвлөгдсөн асуудлыг хэлэлцэж дууслаа. Хэлэлцсэн асуудал бүрээр тогтоол гарна. Тогтоолын төслөө батлах уу?


Оролцогчид 100%: Батлая.

Ё.Энхтөр: Шинээр болон улиран сонгогдсон ТУЗ-ийн гишүүдэд баяр хүргэе. Хувьцаа эзэмшигчдэд хуралд оролцсонд баярлалаа.

Үүгээр хурал 13:00 цагт дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:  Н.Батцэцэг /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Танилцсан:  Ё.Энхтөр /Хурлын дарга/

 Ц.Зоригт: /ТУЗ-ийн дарга/